

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал.....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	16
3.7. Шилэн дансны мэдээлэл	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.9. Аудитын илрүүлэлт	18
Аудитын зөвлөмж	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	18
4. Менежментийн захидал.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ДУУРЬ БҮЖГИЙН
ЭРДМИЙН ТЕАТРЫН ЗАХИРАЛ
Ц.ТӨВШИНТӨГС ТАНАА

2021.02.25 № 07/580
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Аудитын хүрээнд бусад асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 85 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,083,480,810.19	1,211,823,330.85
33	АВЛАГА	1,870,586.68	24,196,269.10
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,870,586.68	24,196,269.10
34	УРЬДЧИЛГАА	-	6,650,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	6,650,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,081,610,223.51	1,180,977,061.75
351	Түүхий эд материал	57,837,988.31	58,104,971.18
35110	Тусгай зориулалттай материал	5,529,888.31	4,999,333.40
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	52,308,100.00	53,105,637.78
354	Хангамжийн материал	1,023,772,235.20	1,122,872,090.57
35410	Бичиг хэргийн материал	798,845.00	1,189,600.00
35420	Аж ахуйн материал	161,209,994.65	134,999,428.15
35430	Сэлбэг хэрэгсэл	86,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	900,000.00	357,138.90
35470	Бусад хангамжийн материал	860,777,395.55	986,325,923.52
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,697,340,298.78	3,408,873,999.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,697,340,298.78	3,408,873,999.47
392	Биет хөрөнгө	3,486,294,098.19	3,198,508,354.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,128,338,957.19	3,128,338,957.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	(210,326,228.40)	(420,652,456.74)
39205	Машин тоног төхөөрөмж	121,920,000.00	116,920,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(91,520,000.02)	(89,720,000.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	236,127,983.34	234,322,780.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(197,395,675.73)	(201,196,977.63)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	12,715,000.00	12,715,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	351,149,730.00	351,149,730.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(244,863,774.03)	(263,677,231.16)
393	Биет бус хөрөнгө	211,046,200.59	210,365,645.00
39301	Програм хангамж	7,161,174.00	5,725,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,480,618.41)	(5,725,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	210,365,645.00	210,365,645.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,780,821,108.97	4,620,697,330.32
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	35,855.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	35,855.00	0.00
413	Өглөг	35,855.00	0.00
4136	Бусад өглөг	35,855.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	35,855.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,780,785,253.97	4,620,697,330.32
51	Засгийн газрын хувь оролцоо	1,684,145,237.5	1,684,145,237.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	1,684,145,237.49	1,684,145,237.49
51101	Өмч: - төрийн	1,684,145,237.5	1,684,145,237.49

512	Хуримтлагдсан үр дүн	(769,728,718.8)	(929,816,642.45)
51210	Өмнөх үеийн үр дүн	(769,728,718.8)	(769,728,718.80)
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	(160,087,923.65)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,866,368,735.28	3,866,368,735.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,780,821,108.97</u>	<u>4,620,697,330.32</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,191,095,214.00	4,706,189,020.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,571,613.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,571,613.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,571,613.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,571,613.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,189,523,601.00	4,706,189,020.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,652,935,200.00	4,536,382,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,652,935,200.00	4,536,382,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	536,588,401.00	169,806,920.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	536,588,401.00	169,806,920.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,370,032,955.44	4,866,276,943.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,253,607,532.65	4,423,388,939.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,253,607,532.65	4,423,388,939.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,934,732,549.37	3,337,255,656.12
210101	Үндсэн цалин	2,276,181,282.07	2,017,486,896.78
210102	Нэмэгдэл	443,091,267.30	1,097,902,039.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	215,460,000.00	221,866,720.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	368,974,846.95	421,589,419.09
210201	Тэтгэврийн даатгал	255,411,246.95	279,521,719.09
210202	Тэтгэмжийн даатгал	28,390,900.00	35,516,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,712,700.00	28,413,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	10,410,200.00	7,103,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	52,049,800.00	71,033,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,641,421.14	84,361,261.26
210301	Гэрэл, цахилгаан	65,698,729.00	40,279,530.00
210302	Түлш, халаалт	41,063,307.14	39,998,180.37
210303	Цэвэр, бохир ус	4,879,385.00	4,083,550.89
2104	Хангамж, бараа материалын зардал	36,476,031.10	52,679,100.08
210401	Бичиг хэрэг	3,367,880.00	3,141,565.00
210402	Тээвэр, шатахуун	8,955,600.00	3,759,861.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,697,857.07	5,020,684.48
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,468,000.00	5,871,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,986,694.03	10,665,635.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	24,219,854.50
2105	Нормативт зардал	16,056,931.78	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,056,931.78	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	80,268,300.00	13,673,886.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	3,684,016.00
210604	Урсгал засвар	80,268,300.00	9,989,870.00
2107	Томилолт, зочны зардал	22,643,600.00	0.00
210702	Дотоод албан томилолт	22,643,600.00	0.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	319,056,134.69	161,376,658.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	312,696,034.69	155,631,388.95
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,961,000.00	2,945,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	190,500.00	122,420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	219,100.00	0.00
210807	Газрын төлбөр	901,500.00	677,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	363,757,717.62	352,452,958.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	327,000.00	1,442,259.03
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	363,430,717.62	351,010,699.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	116,425,422.79	442,888,003.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	112,627,535.00	197,345,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,976,400.00	195,345,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	94,651,135.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,797,887.79	245,542,603.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,797,887.79	245,542,553.81
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	50.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(178,937,741.44)</u>	<u>(160,087,923.65)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(178,937,741.44)</u>	<u>(160,087,923.65)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,189,523,601.00	4,706,189,020.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,189,523,601.00	4,706,189,020.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,652,935,200.00	4,536,382,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,652,935,200.00	4,536,382,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	536,588,401.00	169,806,920.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	536,588,401.00	169,806,920.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,209,526,919.00	4,706,189,020.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,209,526,919.00	4,706,189,020.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,098,907,896.21	4,240,663,516.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,936,800,622.09	3,337,200,694.29
210101	Үндсэн цалин	2,277,259,822.09	2,017,431,934.95
210102	Нэмэгдэл	444,080,800.00	1,097,902,039.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	215,460,000.00	221,866,720.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	367,124,993.91	421,368,418.34
210201	Тэтгэврийн даатгал	253,561,393.91	279,300,718.34
210202	Тэтгэмжийн даатгал	28,390,900.00	35,516,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,712,700.00	28,413,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,678,200.00	7,103,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	56,781,800.00	71,033,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,641,421.14	84,361,261.26
210301	Гэрэл, цахилгаан	65,698,729.00	40,279,530.00
210302	Түлш, халаалт	41,063,307.14	39,998,180.37
210303	Цэвэр, бохир ус	4,879,385.00	4,083,550.89
2104	Хангамж, бараа материалын зардал	26,778,591.07	26,820,344.48
210401	Бичиг хэрэг	4,127,550.00	3,252,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.00	3,217,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,697,857.07	5,020,684.48
210404	Ном, хэвлэл	1,285,000.00	483,180.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,468,000.00	5,871,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,200,184.00	8,975,980.00
2105	Нормативт зардал	30,000,000.00	16,100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,000,000.00	16,100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	148,903,000.00	57,209,470.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	46,172,000.00	42,068,600.00
210602	Тавилга	19,165,000.00	4,350,000.00
210604	Урсгал засвар	83,566,000.00	10,790,870.00
2107	Томилолт, зочны зардал	13,000,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	13,000,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	443,975,850.00	280,523,727.82

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	437,453,650.00	274,397,257.82
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,961,000.00	2,945,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	190,500.00	63,720.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	58,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	381,200.00	381,200.00
210807	Газрын төлбөр	901,500.00	677,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,683,418.00	17,079,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,683,418.00	17,079,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	110,619,022.79	465,525,503.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	106,821,135.00	197,345,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,976,400.00	195,345,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	88,844,735.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,797,887.79	268,180,103.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,797,887.79	245,542,553.81
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,797,887.79	22,637,550.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(20,003,318.00)</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(20,003,318.00)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	(20,003,318.00)	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,684,145,237.49	3,866,368,735.28	(590,790,977.36)	4,959,722,995.41
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(178,937,741.44)	(178,937,741.44)
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,684,145,237.49	3,866,368,735.28	(769,728,718.80)	4,780,785,253.97
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(160,087,923.65)	(160,087,923.65)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,684,145,237.49	3,866,368,735.28	(929,816,642.45)	4,620,697,330.32

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,536,382,100.00	4,290,839,546.19	245,542,553.81	94.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,536,382,100.00	4,290,839,546.19	245,542,553.81	94.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,339,036,700.00	4,093,494,146.19	245,542,553.81	94.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,551,583,100.00	3,337,200,694.29	214,382,405.71	94.0
210101	Үндсэн цалин	2,451,636,100.00	2,017,431,934.95	434,204,165.05	82.3
210102	Нэмэгдэл	884,487,000.00	1,097,902,039.34	-213,415,039.34	124.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	215,460,000.00	221,866,720.00	-6,406,720.00	103.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	443,961,600.00	421,368,418.34	22,593,181.66	94.9
210201	Тэтгэврийн даатгал	301,893,900.00	279,300,718.34	22,593,181.66	92.5
210202	Тэтгэмжийн даатгал	35,516,900.00	35,516,900.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	28,413,500.00	28,413,500.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	7,103,400.00	7,103,400.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	71,033,900.00	71,033,900.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,139,300.00	84,361,261.26	7,778,038.74	91.6
210301	Гэрэл, цахилгаан	44,347,100.00	40,279,530.00	4,067,570.00	90.8
210302	Түлш, халаалт	42,215,200.00	39,998,180.37	2,217,019.63	94.7
210303	Цэвэр, бохир ус	5,577,000.00	4,083,550.89	1,493,449.11	73.2
2104	Хангамж, бараа материалын зардал	26,394,800.00	26,320,344.48	74,455.52	99.7
210401	Бичиг хэрэг	2,752,000.00	2,752,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	3,217,000.00	3,217,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,095,100.00	5,020,684.48	74,415.52	98.5
210404	Ном, хэвлэл	483,200.00	483,180.00	20.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,871,500.00	5,871,500.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,976,000.00	8,975,980.00	20.00	100.0
2105	Нормативт зардал	16,100,000.00	16,100,000.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,100,000.00	16,100,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,931,300.00	3,915,200.00	16,100.00	99.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,950,300.00	2,934,200.00	16,100.00	99.5
210604	Урсгал засвар	981,000.00	981,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	204,647,800.00	203,949,427.82	698,372.18	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	197,849,400.00	197,822,957.82	26,442.18	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,000,000.00	500,000.00	80.0
210803	Даатгалын үйлчилгээ	2,961,000.00	2,945,150.00	15,850.00	99.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	190,500.00	63,720.00	126,780.00	33.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	58,700.00	29,300.00	66.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	381,200.00	381,200.00	0.00	100.0

210807	Газрын төлбөр	677,700.00	677,700.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	278,800.00	278,800.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	278,800.00	278,800.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	197,345,400.00	197,345,400.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	197,345,400.00	197,345,400.00	0.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	195,345,400.00	195,345,400.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,536,382,100.00	4,290,839,546.19	245,542,553.81	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,536,382,100.00	4,290,839,546.19	245,542,553.81	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,536,382,100.00	4,290,839,546.19	245,542,553.81	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	285	285		100.0
620001	Удирдах ажилтан	2	2		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	226	226		100.0
620003	Үйлчлэх ажилтан	57	57		100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	169,806,920.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	169,806,920.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	147,169,370.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	500,000.00
210401	Бичиг хэрэг	-	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	53,294,270.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	39,134,400.00
210602	Тавилга	-	4,350,000.00
210604	Урсгал засвар	-	9,809,870.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	76,574,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	76,574,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	16,800,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	16,800,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		22,637,550.00
2132	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		22,637,550.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		22,637,550.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	169,806,920.00
1311	НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	169,806,920.00
	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	169,806,920.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын захирал Ц.Төвшинтөгс танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн элэгдлийг зөв тооцох, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох маягыг хавсаргах, хэвлэлийн чанарын шаардлагад нийцүүлэх зөвлөмжүүдийг өгч, менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, Үндэсний аудитын газрын захиалгаар “Ниямазон аудит” ХХК-ийн захирал З.Цээнээ, аудитын менежер Ж.Батнасан, аудитор Ж.Ядмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театр нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 26 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

- Уран бүтээлч, соёлын ажилтны мэргэжлийн ур чадварт тулгуурлан үндэсний болон сонгодог урлагийн бүтээлээр иргэдэд үйлчлэх,
- Алслагдсан аймаг, дүүргийн иргэдэд тогтмол үйлчлэх,
- Соёлын арга хэмжээ, тоглолт үйлчилгээг олон түмэнд хүргэж сурталчлах менежментийг боловсронгуй болгох,
- Байгууллагын үйл ажиллагааг материаллаг орчин нөхцөлөөр сайжруулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Уран бүтээлийн чанарыг өндөр түвшинд гаргаж уран бүтээлчдийн ур чадварыг дээшлүүлэх,
- Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн тэлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоол “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоол “Соёлын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай”

- 2019 оны 11 дүгээр сарын 13-нд Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-д “Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно” гэсэн нэмэлт өөрчлөлт тус тус орсон байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Улсын дуурь бүжгийн эрдмийн театр нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театр нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тооцож 2,094,239.3 мянган төгрөгийн нийт зардлаас 20,942.4 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн тайлангийн 4,620,697.3 мянган төгрөгийн нийт хөрөнгийн 1 хувиар буюу 46,207.0 мянган төгрөгөөр тогтоож баталгаажууллаа.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 160,123.8 мянган төгрөгөөр буюу 3.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	1,870.6	24,196.3	22,325.7
Урьдчилгаа	-	6,650.0	6,650.0
Бараа материал	1,081,610.2	1,180,977.1	99,366.8
Үндсэн хөрөнгө	3,697,340.3	3,408,874.0	(288,466.3)
Нийт хөрөнгө	4,780,821.1	4,620,697.3	(160,123.8)
Өр төлбөр	35.9	-	(35.9)
Засгийн газрын оролцоо/ Эздийн өмч	4,780,785.3	4,620,697.3	(160,087.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө/ өмчийн дүн	4,780,821.1	4,620,697.3	(160,123.8)

Авлага дансны үлдэгдэл 24,196.3 мянган төгрөг болж 22,325.7 мянган төгрөгөөр өссөн нь Сангийн яам татан төвлөрүүлсэн, нэмэлт санхүүжилтээс үлдсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл нь Монголын урлагийн ажилтны холбоо ТББ-тай хамтран 2021 онд эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахаар шилжүүлсэн 6,650.0 мянган төгрөг юм.

Бараа материалын дансны үлдэгдэл 99,366.8 мянган төгрөгөөр өссөн нь 216,048.4 мянган төгрөгийн жүжгийн хувцас, хэрэглэл, бичиг хэрэг, шатах тослох, аж ахуйн материал худалдан авч, 233,308.7 мянган төгрөгийн данснаас дансанд шилжүүлсэн, акталсан, зарцуулсан гүйлгээ хийснээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,408,874.0 мянган төгрөг болж 288,466.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 58,194.4 мянган төгрөгийн хөгжим, тоног төхөөрөмж хэрэгсэл, 4,350.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, 351,010.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ. Тайлант онд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглах боломжгүй 17 нэр төрөл бүхий нийт 12,783.9 төгрөгийн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн № А1/1185 тоот зөвшөөрлөөр данснаас хасжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,620,697.3 мянган төгрөг болж 160,087.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалжээ.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 515,093.8 мянган төгрөгөөр буюу 12.3 хувиар өссөн нь улсын төсвийн урсгал санхүүжилт өссөнөөс шалтгаалсан байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 4,536,382.1 мянган төгрөгийн төсөв батлагдсаныг урсгал зардалд зарцуулж, гүйцэтгэл 94.6 хувьтай гарсан байна.

Үндсэн үйл ажиллагааны өөрийн орлого 169,806.9 мянган төгрөг болж өмнөх оноос 366,781.5 мянган төгрөгөөр буурсан нь Ковид-19 цар тахалтай холбоотой хөл хорио, эдийн засгийн хямралаас шалтгаалсан байна. Оны эцэст 22,637.5 мянган төгрөгийг Сангийн яамтай хоорондын тооцоогоор авлагаар бүртгэсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 496,244.0 мянган төгрөгөөр буюу 11.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, тэтгэвэрт гарахад олгосон нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад урсгал шилжүүлэг, төвлөрүүлэх шилжүүлэг байна. Энэ нь нэмэгдэл цалин, урамшуулал олгосон болон тэтгэвэрт гарсан ажилтны тоо, нийгмийн даатгалын шимтгэл өссөнтэй холбоотой байна. Мөн оны эцэст татан төвлөрүүлсэн шилжүүлэг 245,542.6 мянган төгрөг байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2019 оны батлагдсан төсөв нь 3,652,935.2 мянган төгрөг байсан бөгөөд Засгийн газрын 382 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу ажилтан, албан хаагчдын ур чадвар, ажилласан жилийн нэмэгдлийг тооцон цалин хөлс, нийгмийн даатгалын зардлыг 690,111.9 мянган, төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг 207,568.9 мянган, эд хогшил худалдан авах зардлыг 59,790.7 мянган, тогтмол зардал, харуул хамгаалалт, хангамжийн материал,

дотоод томилолт зэрэг зардлыг 103,150.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн тооцож 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,713,557.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,713,557.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагч нь төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг үндсэн цалингаас бус нэмэгдлийг оруулсан дүнгээс тооцсон, ковид цар тахлын давагдашгүй хүчин зүйл зэрэг шалтгаанаар 177,175.3 мянган төгрөгөөр бууруулж 4,536,382.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,536,382.1 мянган төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,536,382.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 4,290,839.5 мянган төгрөгийг зарцуулж 245,542.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,290,839.5 мянган төгрөг буюу 94.6 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 214,382.4 мянган төгрөгөөр, ашиглалтын зардлыг 7,778.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Тайлант онд гадаад, дотоод албан томилолтын зардал гараагүй, хэмнэгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд 169,806.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, эд хогшил худалдан авахад 53,294.3 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 76,574.3 мянган, бараа үйлчилгээний бусад зардалд 16.800 мянган, бичиг хэргийн зардалд 500.0 мянган, улсын төсөвт 22,637.5 мянган төгрөг төвлөрүүлж нийт 169,806.9 мянган төгрөгийг зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 109, хугацаа хоцроосон 36, шилэн дансны цахим хуудсанд 3 мэдээллийг огт байршуулаагүй байна.

Тус байгууллага зарим худалдан авалтыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай”- хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2-т “оюуны өмчийн эрх, соёлын биет өвийг хамгаалах шаардлагаар гэрээг зөвхөн нэг этгээдтэй байгуулах боломжтой бөгөөд түүнийг орлох этгээд байхгүй бол” гэсэн заалтын дагуу гэрээ шууд байгуулах аргыг ашиглан шууд гэрээгээр худалдан авсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 ажилтныг ажлаас үндэслэлгүй чөлөөлсний улмаас шүүхийн шийдвэрээр 5,872.3 мянган төгрөг олгосон, хувь хүнд олгосон орлогоос 1,599.3 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар дутуу суутгасан зөрчилд 7,471.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг бүрэн биелүүлсэн байна.

Аудитаар байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбоотой үйл ажиллагааны орлогыг төсөвт тусгах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	7,471.7	2	7,471.7	-	-	100%
Зөвлөмж	2	-	2	-	-	-	100%
Нийт дүн	4	7,471.7	4	7,471.7	-	-	100%

/мянган төгрөг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 738.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 738.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, 1 албан шаардлага өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Албан шаардлага

Тус байгууллагын шилэн дансны мэдээллийг шалгаж үзэхэд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө /бүтэн жилээр/, худалдан авах ажиллагааны тайлан /бүтэн жилээр/, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 болон 6.4 дэх заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн

Шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй зөрчилд албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 738.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

- Байгууллагын худалдан авах ажиллагаа нь худалдан авалтын төлөвлөгөөний дагуу болон “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай”- хуулийн хүрээнд явагдсан эсэхэд анхаарал хандуулах шаардлагатай байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд худалдан авсан нэр бүхий 6 төрлийн үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжид 738.4 мянган төгрөгийн элэгдэл тооцоолоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.3 “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт” гэсэнтэй нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Тайлант хугацааны элэгдлийн зардал дутуу илэрхийлэгдэх

1.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцохдоо холбогдох журам зааврын дагуу бүрэн тооцоолол хийж байх

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлоготой холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тус байгууллагын 2020 оны 12 дугаар сард шинээр баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хавсралтаар Сангийн сайдын баталсан тушаалаар баталсан анхан шатны маягт, маягтыг хөтлөх заавар, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн загвар, гаргах аргачлал, нягтлан бодох бүртгэл, төсөвтэй холбоотой тушаал, шийдвэр, журам зааврыг оруулаагүй байна.

2.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

Гаднын хэрэглэгчдийг шаардлагатай мэдээллээр хангаж чадахгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох материалуудыг хавсаргах, хэвлэлтийн чанарын шаардлагад нийцүүлэх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021./70/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Улсын дуурь бүжгийн эрдмийн театр		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Нэр бүхий 6 нэр төрлийн үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоолоогүй 738.4 мянган төгрөг байна.	738.4	Зөвлөмж	УДБЭТ-ын Захирал Нягтлан бодогч	Ц.Төвшинтөгс Н.Анхтөр
2	Тус байгууллагын 2020 оны 12 дугаар сард шинээр баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хавсралтаар Сангийн сайдын баталсан тушаалаар баталсан анхан шатны маягт, маягтыг хөтлөх заавар, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн загвар, гаргах аргачлал, нягтлан бодох бүртгэл, төсөвтэй холбоотой тушаал, шийдвэр, журам зааврыг оруулаагүй байна.	-	Зөвлөмж	УДБЭТ-ын Захирал Нягтлан бодогч	Ц.Төвшинтөгс Н.Анхтөр
3	Шилэн данс /www.shilendans.gov.mn/-нд 3 мэдээллийг байршуулаагүй байна.	-	Албан шаардлага	УДБЭТ-ын Захирал Нягтлан бодогч	Ц.Төвшинтөгс Н.Анхтөр
ДҮН		738.4			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 206/А0160058
САГ- 2021/70 /СТА-ТЦЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 148 мэдээллээс 3 мэдээллийг огт байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;" , 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, тогтоосон хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын захирал Ц.Төвшинтөгс, ерөнхий нягтлан бодогч Н.Анхтөр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ

АХЛАХ АУДИТОР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
НИЯМАЗОН АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

З.ЦЭЭНЭЭ

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing a summary.